

- Улс төрийн тогтолцооны бусад бүрдлүүдэд үл хамаарах, зөвхөн төрд л хамаарах онцлог шинж аль вэ?
  - Хүн ам
  - Нутаг дэвсгэр
  - Нийтлэг эрх мэдэл
  - Дээрх бүгд

2. Г.Алмондын сонирхлын бүлгийн ангилалыг зөв харгалзуулаарай.

<b>Амоник</b>	Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг
<b>Эвсэл холбооны</b>	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт
<b>Эвсэл холбооны бус</b>	Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийн шууд удидлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулагддаг.
<b>Байгууллагажсан</b>	Зохион байгуулалтгүй боловч яс үндэс, угсаа гарал, арьс өнгө, шашин шүтлэг, нас хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг

3. Сонирхлын бүлгийн чиг үүргийг зөв харгалзуулаарай.

<b>Артикуляци</b>	• Сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэх
<b>Агрегаци</b>	• Сонирхлыг цэгцлэн, нэгтгэн боловсруулах
<b>Интеграци</b>	• Сонирхлыг илрүүлэн гаргах

- Засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх хоёр намаас бүрддэг, сонгуульд нэг нам нь ялахад нөгөө нь сөрөг хүчин болж харилцан засгийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг тогтолцоог ..... гэнэ.
  - Нэг намын тогтолцоо
  - Хоёр намын тогтолцоо
  - Олон намын тогтолцоо
- Олон намтай байхын ач холбогдолуудад үл хамаарах өгөгдөл аль вэ?
  - Нэг намын ноёрхол тогтох үйл явцыг хязгаарладаг
  - Олон ургальч үзлийг дэмжих боломж бүрдэнэ
  - Эрх мэдлийн төвлөрөл бий болох нөхцөл бүрдэнэ
  - Засаглалын тэнцвэр хадгалах нөхцөл бүрдэнэ
- Сонгуулийн тогтолцоог хэрхэн ангилдаг вэ?
  - Мажоритари, Пропорциональ, холимог
  - Мажоритари Харьцангуй олонх, үнэмлэхүй олонх
  - Дийлэнх олонх, Харьцангуй олонх, Пропорциональ
  - Пропорциональ, Хувь тэнцүүлэх, Дийлэнх олонх
- Сонгуульд өрсөлдөгчөөсөө илүү санал авсан нь ялалт байгуулдаг. Дотроо энгийн олонх, үнэмлэхүй олонх, харьцангуй олонх гэсэн аргатай сонгуулийн тогтолцоо аль нь вэ?
  - Холимог
  - Пропорциональ
  - Мажоритар
  - Уламжлалт

8. Сонгуульд нэр дэвшигч сонгогдохын тулд 50 хувиас дээш санал авсан байх ёстой гэсэн шаардлага ямар тогтолцоонд хамаарах вэ?
- A. Энгийн олонхийн  
B. Харьцангуй олонхийн  
C. Хувь тэнцүүлэх  
D. Холимог тогтолцоо
9. Өрсөлдөгчдөөсөө илүү олон санал авсан байх ёстой гэсэн шаардлага ямар тогтолцоонд хамаарах вэ?
- A. Энгийн олонхийн  
B. Харьцангуй олонхийн  
C. Хувь тэнцүүлэх  
D. Холимог тогтолцоо
10. Намуудаас нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаар санал хураах нь сонгуулийн ямар тогтолцоонд хамаарах вэ?
- A. Энгийн олонхийн  
B. Харьцангуй олонхийн  
C. Хувь тэнцүүлэх  
D. Холимог тогтолцоо
11. Хувь тэнцүүлэх болон дийлэнх олонхийн тогтолцооны аль алиных нь онцлог шинжийг хадгалсан байдаг сонгуулийн системийг тэмдэглэнэ үү.
- A. Энгийн олонхийн  
B. Харьцангуй олонхийн  
C. Хувь тэнцүүлэх  
D. Холимог тогтолцоо
12. Монгол улсын ерөнхийлөгчийн сонгууль сүүлийн жилүүдэд аль хэлбэрээр явагдсан бэ?
- A. Дийлэнх олонхийн тогтолцооны энгийн олонхийн хэлбэрээр  
B. Дийлэнх олонхийн тогтолцооны харьцангуй олонхийн хэлбэрээр  
C. Энгийн олонхийн тогтолцооны дийлэнх олонхийн хэлбэрээр  
D. Энгийн олонхийн тогтолцооны харьцангуй олонхийн хэлбэрээр
13. Монголд УИХ, ИТХ-ын сонгууль аль хэлбэрээр явагддаг вэ?
- A. Дийлэнх олонхийн тогтолцооны энгийн олонхийн хэлбэрээр  
B. Дийлэнх олонхийн тогтолцооны харьцангуй олонхийн хэлбэрээр  
C. Энгийн олонхийн тогтолцооны дийлэнх олонхийн хэлбэрээр  
D. Энгийн олонхийн тогтолцооны харьцангуй олонхийн хэлбэрээр
14. Сонгуулийн зарчимуудыг зөв харгалзуулаарай.

<b>Бүх нийтийн зарчим</b>	<ul style="list-style-type: none"> <li>Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй</li> </ul>
<b>Тэгш эрхийн зарчим</b>	<ul style="list-style-type: none"> <li>Сонгуульд оролцохдоо чөлөөтэй сонголт хийн, саналаа чөлөөтэй илэрхийлэх бүхий л тогтолцоогоор хангагдах</li> </ul>
<b>Шууд зарчим</b>	<ul style="list-style-type: none"> <li>Нас, хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл санхүүгийн чадвар, үзэл бодлоос үл шалтгаалан бүгд оролцох</li> </ul>
<b>Чөлөөтэй байх зарчим</b>	<ul style="list-style-type: none"> <li>Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдлыг хангах</li> </ul>
<b>Саналаа нууцаар гаргах зарчим</b>	<ul style="list-style-type: none"> <li>Сонгуулийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг байх</li> </ul>

--	--